

СОЁМБО МЭДЭЭ

/ТУСГАЙ ДУГААР/

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.25. №82 (82)

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЦАЦРАГ, ХИМИ, БИОЛОГИОС ХАМГААЛАХЫН ЦЭРЭГ ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 85 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ХҮРГЭЭ!

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчид, дэлхийн халуун цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчид, эх орноо батлан хамгаалах үйлсэд эрдэм ухаан, хөдөлмөр зүтгэлээ зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид Та бүхэндээ Зэвсэгт хүчний химийн цэргийн түүхт 85 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье!

Эдүгээгээс 85 жилийн тэртээ БНМАУ-ын Цэргийн явдлын яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 1936 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 101 дүгээр тушаалаар Монгол Ардын Хувьсгалт Цэргийн үндсэн нэгтгэлүүдэд химийн салаадыг байгуулан орон тоо, хими хамгаалалтын техник, эд хэрэгслээр нөхөн хангаж, тусгай мэргэжлийн сургалт бэлтгэлийг явуулж эхэлснээр Химийн цэрэг хэмээх шинэ төрөл мэргэжлийн цэрэг бий болсон түүхтэй.

Энэхүү ойн баяр нь Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, Ардын хувьсгалын 100, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 110, орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ой зэрэг түүхэн тэмдэглэлт баяр тохиосон жил болж буйгаараа онцлогтой.

Тиймээс химийн цэргийн үүсэл, хөгжил, дайчин уламжлал, бүтээлч үйл ажиллагаа нь Зэвсэгт хүчний хөгжлийн бүхий л үе шаттай салшгүй холбоотой бөгөөд түүхэнд тэмдэглэгдэх бахдам үйлс, бахархам гавьяагаараа бусад төрөл мэргэжлийн цэрэгт бодит үлгэр дуурайл үзүүлсээр ирсэн баялаг туршлагатай билээ.

Зэвсэгт хүчний Химийн цэрэг нь 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд химийн хангалтын үүргийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж ирсний дээр энх цагийн өнөөгийн нөхцөлд үйл олноор хөнөөх зэвсгээс хамгаалах, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, бие бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, үйлдвэрлэлийн осол, хүн, малын гоц халдварт өвчин, байгалийн гамшгаас хүн ам, эд баялгийг авран хамгаалах, хор уршиггүй нь арилгах үйл хэрэгт жинтэй хувь нэмэр оруулсаар байна.

Тэрчлэн 1996 оноос Нидерландын Вант Улсын Гаага хотноо Нобелийн Энх тайвны шагнал хүртсэн Химийн зэвсгийг хориглох олон улсын байгууллагын шинжээчээр бригадын генерал М.Хүрлээ, хурандаа З.Нармандах, Д.Эрдэнэцогт нар үүргээ амжилттай гүйцэтгэн, НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд анхлан үүрэг гүйцэтгэгчдийн тоонд химийн мэргэжлийн офицер, ахлагч нар зүй ёсоор тооцогдож, даян дэлхийд энх амгаланг тогтоох үйл хэрэгт идэвхийлэн оролцооор байгаа бид өндөрөөр үнэлдэг юм.

Зэвсэгт хүчний Химийн төрөл мэргэжлийн цэргээс 1921 оны Ардын хувьсгалын партизан, Химийн цэргийн анхны дарга П.Нямхүү, 1939, 1945 оны дайнд оролцсон хурандаа Я.Жамц, С.Гомбодорж, дэд хурандаа С.Даваа нарын олон арван ахмад дайчин, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж, Үйлчилгээний гавьяат ажилтан, доктор, хурандаа П.Дамдин, хошууч генерал Ж.Дашзэвэг, Ч.Самбуу, хурандаа Д.Налжир, Р.Даваа, Ш.Банзрагч, Н.Чимэд,

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА, ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ



С.Пүрэвдорж, Д.Нарантулга, П.Цогтбаатар нарын олон алдартан төрснийг баярын энэ өдөр онцлон тэмдэглэе.

Өнөөгийн химийн цэргийн анги, салбарууд нь гадаад, дотоод цэргийн их, дээд сургууль төгссөн мэргэжлийн бүрэлдэхүүнээр бүрэн хангагдсан, тусгай тоноглолтой техник хэрэгслийн үүрэг гүйцэтгэх боломж, тэдгээрт ажиллах бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар үлэмж нэмэгдсэн, энхийг дэмжих ажиллагаа болон олон улсын сургалт, дадлагад амжилттай оролцон үүрэг гүйцэтгэх дадлага, туршлагыг ихээр хуримтлуулсан, цаг улирал, цагийн байдлын ямар ч нөхцөлд тавигдсан үүргийг нэр төртэй гүйцэтгэх чадавх дээшилсэн зэрэг амжилтуудаар түүхт ойгоо угтаж байна.

Цаашид ч төрийн цэргийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үндсэн болон бусад үүргүүдийг амжилттай гүйцэтгэх, химийн мэргэжлийн анги, салбаруудын үүрэг гүйцэтгэх боломж, бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, ур чадварыг улам нэмэгдүүлэх, сургалт бэлтгэлийн чанарыг ахиулах, цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, ахуй хангалт, ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зэрэг бүтээлч үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах болно.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үе нь химийн цэргийн гүйцэтгэх үүрэг, оролцоо, ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж буйг онцгой анхаарч, иргэдийг цар тахлын аюулаас хамгаалах үйлсэд өөрийн мэдлэг, дадлага, туршлагадаа тулгуурлан үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэл төгс байна.

Түүхт ойг тохиолдуулан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, химийн цэргийн нэр хүндийг өндөрт өргөж яваа генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч нартаа дахин баярын мэндчилгээ дэвшүүлж, ажил, албаны арвин их амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн өрөөе.

Монгол цэргийн яруу алдар, сүр хүч, сүлд хийморь мандан бадрах болтугай!

Монгол Улсынхаа тусгаар тогтнол, улс орныг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл хэрэг, хөгжил дэвшилд ухамсарт амьдрал, хөдөлмөр зүтгэлээ зориулсан үе үеийн цэргийн химичид, өдгөө химичин дайчдын замналыг нэр төртэй үргэлжлүүлж яваа офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагч нартаа орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жил, химийн цэрэг үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Батлан хамгаалах яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны нэгдүгээр орлогчийн 1936 оны 101 дүгээр тушаалаар морьт дивизүүдэд химийн салааг анх байгуулсан нь Монгол Улсын Зэвсэгт хүчинд химийн цэрэг үүсэж хөгжих эхлэл суурь нь болсон түүхтэй бөгөөд өдгөө 85 дахь жилтэйгээ золгож байна.

Эх орныхоо тусгаар тогтнолын баталгаа нь болж өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн, Зэвсэгт хүчний хөгжил, дэвшлийн төлөө үнэлж баршгүй хувь нэмэр оруулж, Монгол цэргийн баатарлаг түүхийг түүчээлэн яваа химичин дайчдынхаа алдар гавьяа, амжилт бүтээлийг баярын энэ өдөр бахархан тэмдэглэхэд таатай байна.

Химийн цэрэг нь дайн байлдааны үед химийн хангалтыг зохион байгуулж хэрэгжүүлэхээс гадна энх цагт улс орондоо тохиолдож болох байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, хүн, малын гоц халдварт өвчин, тэдгээрийн хор уршигийг арилгахад тэргүүн эгнээнд үүрэг гүйцэтгэдэг Зэвсэгт

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ ХОШУУЧ ГЕНЕРАЛ Б.АМГАЛАНБААТАР



“ХИМИЙН ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО” ТББ-ЫН ТЭРГҮҮН, ДОКТОР (Ph.D), БЭЛТГЭЛТ БРИГАДЫН ГЕНЕРАЛ М.ХҮРЛЭЭ

Зэвсэгт хүчний цацраг, хими, биологис хамгаалахын цэрэг нь анх Цэргийн явдлын Яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 1936.6.27-ны өдрийн №101 дүгээр “Химийн салаадыг байгуулах тухай” тушаалаар Монгол Ардын Хувьсгалт цэргийн 5, 6, 7, 8 дугаар дивизэд химийн салааг байгуулснаар Зэвсэгт хүчний цацраг, хими, биологис хамгаалахын цэрэг үүсэн байгуулагдах үндсэн суурийг тавьсан юм.

Цацраг, хими, биологис хамгаалахын цэргийн хөгжлийг 4 бүлэгт хуваадаг бөгөөд I бүлэгт Монгол Ардын Хувьсгалт цэрэгт химийн цэргийн анги, салбар үүсэж хөгжсөн үе /1936-1955 он/, II бүлэгт химийн цэргийг шинэчлэн байгуулсан үе /1956-1964 он/, III бүлэгт химийн цэргийн хөгжлийн шинэ үе /1965-1990 он/, IV бүлэгт химийн цэргийн хөгжлийн шинэ үе /1990 оноос хойш/ юм.



хүчинд төдийгүй эх орондоо нэн хариуцлагатай, хүндтэй алба юм.

Та бүхэндээ орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жил, Монгол Улсын Зэвсэгт хүчний химийн цэрэг үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойн баярын мэндийг дахин дэвшүүлж, ажлын өндөр амжилт, амьдралын сайн сайхныг хүсэн өрөөе!

Монгол цэргийн сүлд хийморь үеийн үед мандан бадраг.

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀ 22	☾ 9
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀ 37	☾ 24
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀ 33	☾ 16

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.469.00	3.428.00
CNY	437.80	441.60
RUB	38.50	40.20
JPY	25.44	25.93
KRW	2.42	2.56

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 16
2021.06.25.
/БААСАН ГАРАГ/

ЗУНЫ ДҮНД ХӨХ МОРЬ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХӨХ ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:
Өлзийтэй сайн
Наран ургах, шингэх:
04.54-20.55
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Хүрэлцэхүй
Суудал:
Гал

Аргын тооллын 6 дугаар сарын 25, Сугар гараг. Билгийн тооллын 16, Өдрийн наран 4 цаг 54 минутад мандан, 20 цаг 55 минутад жаргана.

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр баяр баясалын хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
102.629	66.602	484/13
НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
3233 (53)	358	2820

ТА ӨӨРТ ТОХИРОХ ВАКЦИНЫГ ТАРИУЛАРАЙ

Вакцин Вероселл, АстрЗенека, Комирнэти

Өмөр нэг шалтгааны улмаас КОВИД-19 өвчний эсрэг вакцин хамрагдаагүй 18-с дээш насны иргэд дархлаажуулалтын цэгт очиж энэцэд үзүүлэн өөрт тохирох вакцинг тариулах боломжтой болно.

ЛУУДИЙН ВАКЦИН ТАРХЖ БҮЙ ЦЭГТ ОЧНО!

КОРОНАВИРУС КОВИД-19 ХАЛДВАРААС СЭРГИЙЛБЭ!

Хүүхдийг КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ААС СЭРГИЙЛБЭ!

ХИМИЙН ЦЭРГИЙН ХӨГЖЛИЙН СУУРЬ ТАВИГДАВ

МАХЦ-т химийн цэргийн анги, салбар үүсэж хөгжсөн нь /1936-1955 он/

Гучаад оны эхэн, дунд үед алс Дорнод хийгээд БНМАУ-ын гадаад, дотоод байдалд гарсан цэрэг, улс төрийн өөрчлөлт, болзошгүй аюулыг үндэслэн улс орныг хамгаалах хүч, МАХЦ-ийг бэхжүүлэх талаар төр засаг, цэргийн дээд удирдлагаас онцгой анхаарч ирсэн. 1937 онд Японоос Манжуурт хорт зайгаар дүүргэсэн төмөр савнуудыг нөөцөлж буй байдлыг дүгнэн БНМАУ-ын аюулгүй байдлыг хангахад химийн цэргийн салбар, боловсон хүчин, техник материал

хэрэгслийг татах, нөөцлөх, бие бүрэлдэхүүнийг сургах талаар онцгой анхаарч байжээ.

Тухай үеийн химийн цэрэг хүний баг, морины баг, хорт бодис /иприт/, утаат шашке зэрэг эд хогшилтой байжээ. Тухайн үед хурандаа Я.Жамц, бүх цэргийн химийн дарга, хурандаа Б.Намсрай, Н.Доржсүрэн, Н.Найданжав, М.Пүрэвжав, партизан П.Нямхүү нар ажиллаж химийн цэргийн хөгжлийн суурийг тавьсан түүхтэй.



ДДА-ийн тоотын ажиллагаа

ТАЙВАН ЦАГТ ГАМШИГТ ҮЗЭГДЛИЙН ХОР УРШИГ, ҮР ДАГАВРЫГ АРИЛГАХАД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОЖ ЭХЛЭВ

Химийн цэргийн хөгжлийн шинэхэн үе /1990 оноос хойш/



Химийн цэргийн хөгжлийн шинэхэн үе нь Монгол улс хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах шинэ зорилтыг үндсэн хуулиараа тунхагласан XXI зууны эхэн үеэс эхэлж байгаагаараа онцлог юм.

Олон улсын цэрэг, улс төрд гарсан өөрчлөлттэй уялдан цэрэг арми улс орноо Батлан хамгаалахын зэрэгцээ олон улсын болон иргэний зориулалттай олон талт үүрэг гүйцэтгэх болсон өнөө үед химийн цэргийн гүйцэтгэх үүрэг, цар хүрээ өргөжиж байна. Үүнтэй уялдан химийн цэргийн бүтэц зохион байгуулалт, зэвсэглэл техник нь цаг үеэ даган өөрчлөгдөн шинэчлэгдэх зүй ёсны шаардлага гарч ирсэн.

Химийн цэргийн бүтэц зохион байгуулалт нь 1980-аад оны сүүлчээс улс орны эдийн засгийн боломж, зах зээлд шилжих болсонтой уялдуулан төр засгаас авч хэрэгжүүлсэн цэрэг армийг цомхотгож, хоргодуулах бодлогын хүрээнд 1989 онд хийсэн Зэвсэгт хүчний шинэ бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Ардын цэргийн 289 дүгээр хими радиацийн тагнуулын тусгай батальон, 235 дугаар анги, Ар талын хими хамгаалалтын тусгай батальонуудыг Зэвсэгт хүчний 119 дүгээр ангитай нэгтгэн Хими хамгаалалтын тусгай батальон болгон Дархан хотын Хөтөл хооронд байршуулжээ. Энэ үед тус анги нь хими радиацийн тагнуулын, тусгай цэвэрлэгээ, хувцас, тоног хэрэгсэл цэвэрлэх болон хангалт үйлчилгээний салбаруудтайгаар зохион байгуулагдсан юм.


Мөн мотобуудлагын төдийгүй бусад төрөл, мэргэжлийн ангиудад химийн алба, эмнэлэг ариутгалын бүлэг, тасгийн зохион байгуулалтад орж тайван цагт Зэвсэгт хүчин байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, цацраг, химийн хордолт, хүн

малын гоц халдварт өвчин, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны үед хүн амын аюулгүй байдлыг хангах, эд баялгийг авран хамгаалахад туслах, үүдэн гарсан хор уршигийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох, иргэний хамгаалалтын чиглэлээр олон талт үүрэг гүйцэтгэж байлаа.

1988 онд Хөтөлийн цементийн үйлдвэрийн цацрагийн осол, 1996 оны Хөтөл хорооны "Булчин задрах тахал", 2000 онд Улаанбаатар, Сүхбаатар, Дорноговь, Хөвсгөл аймгуудад гарсан малын гоц халдварт шүлхий өвчин, Ховд аймгийн Мөст, Мөнххайрхан, Цэцэг, Дуут, Манхан сумдын нутагт бэлчээр сүйтгэгч царцаа устгал, 2001 онд Улаанбаатар, Сүхбаатар, Хэнтий, Орхон, Дорнод аймгуудад гарсан малын гоц халдварт шүлхий өвчний устгал, 2002 онд нийслэлийн ногоон бүсэд гарсан гал түймэр унтраах, 2003 онд Богд уулын ойн хортон шавж устгал, 2004 онд Дорноговь, Сайшанд, Дундговь аймагт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний устгал, 2005 онд Дорнод, Ховд аймгуудад гарсан малын гоц халдварт шүлхий, боом өвчний устгал, 2007 онд Дархан-Уул аймгийн Хонгор суманд "Циант-натри"-ийн хор уршигийг арилгах, 2010 онд Дорнод аймагт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний устгал, 2014 онд Дорноговь, Сүхбаатар аймгуудад гарсан малын гоц халдварт шүлхий өвчний устгал, 2015 онд Ховд, Дорнод аймагт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний устгал, 2016 оны Монгол Улсад зохион байгуулагдсан Ази, Европын 11 дэх удаагийн дээд түвшний уулзалтын аюулгүй байдлыг хангах ажил болон бусад үүргийг гүйцэтгэж тайван цагт гамшигт үзэгдлийн хор уршиг, үр дагаврыг арилгахад идэвхтэй оролцож эхэлсэн түүхтэй юм.

ХҮН АМЫГ ДАЙСНЫ АГААРЫН АТОМ, ХИМИЙН ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХАД БЭЛТГЭГДЭЖ ЭХЛЭВ

Химийн цэргийг шинэчлэн байгуулсан нь /1956-1964 он/



КШХС-д офицерууд

Дэлхийн II дайн ЗХУ болон түүний холбоотны ялалтаар төгсөж, улс орнуудад энхийн бүтээн байгуулалт эхлэв. Гэвч дайны дараагаар гол том гүрнүүд атом, устөрөгч, цөмийн зэвсэгтэй болж, "Хүйтэн дайн"-ы үе улс орнуудын харилцааг тодорхойлох болжээ. Энэ үед

БНМАУ-ын нам, засгаас, хүн ам, эдийн засгийн чухал объектуудыг атом, химийн довтолгооноос хамгаалахад хөдөлмөрчид төдийгүй цэргийн алба хаагчийг сургаж бэлтгэх талаар зохион байгуулалттай арга хэмжээг авч эхэлсэн юм.

Түүнчлэн АНУ, Англи,

Франц, ЗХУ зэрэг улс орнууд цөмийн зэвсэгтэй болж, БНМАУ-ын нам, засгаас улс орны батлан хамгаалах чадварыг дээшлүүлж, ард иргэд, цэргийн алба хаагчдыг шинжлэх ухаан, техникийн орчин цагийн мэдлэг, дадлагатай болгох талаар үндсэн хоёр арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Тодруулбал, нийт хүн амыг дайсны агаарын атом, химийн довтолгооноос хамгаалахад сургаж бэлтгэх, батлан хамгаалах гол цөм болсон ардын цэргийг шинэчлэн байгуулж, цөм, хими, бактериологийн нарийн мэргэжлийн боловсон хүчин, шинэ төрлийн цацраг, химийн тагнуулын техник, багаж, хамгаалах хэрэгсэлтэй болох явдал юм.

Дээрх ажлыг тухайн үед Ардын цэргийн жанжин штабын Химийн хэлтсийн дарга, хурандаа С.Гомбодорж, тухайн үед химийн хэлтэс тасаг, анги, салбарт ажиллаж байсан дэд хурандаа Д.Батаа, Б.Намхайнямбуу, хошууч Л.Гончиг, С.Жанцан нар амжилттай хэрэгжүүлэн

ажилласан түүхтэй.

МАХЦ-ийг 1940, 1950-иад онд татан буулгаж, цомхотгох явцад армийн тусгай ба нэгтгэл, ангиудын бүрэлдэхүүнд байсан химийн цэргийн анги, салбарууд үндсэндээ татан буугдсан бөгөөд 1956 он гэхэд ардын цэргийн буудлагын нэгдүгээр батальоны штабын ротод Химийн салаа үлдсэн байжээ. Мөн энэ үеэс Монголын армид химийн цэргийг шинэчлэн байгуулах эхлэл тавигдаж, 1958 онд Химийн тусгай салааг Ардын цэргийн химийн тусгай рот болгон өөрчлөн байгуулсан юм.

1959 онд химийн цэрэг өргөтгөн зохион байгуулагдаж Ардын цэргийн Ерөнхий штабын харьяа хэлтэс, албадын хамт эмхлэн байгуулж, Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны сайд бөгөөд Ардын цэргийн командлагчийн 1959.7.17-ны өдрийн 14 тоот тушаалаар Ардын цэргийн штабын Химийн хэлтэс байгуулагдсан түүхтэй.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 119 ДҮГЭЭР АНГИ "ОНЦ АНГИ" ХЭМЭЭХ АЛДРЫГ ХҮРТЭВ

Химийн цэргийн хөгжлийн шинэ үе /1965-1990 он/


1964-1979 оны үед төр засаг МАХН-аас улс орны батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх, армийг өргөтгөн зохион байгуулах явцад химийн анги, салбаруудыг өргөтгөх, шинээр зохион байгуулах, шинэ техник хэрэгслээр хангах, гадаад дотоодод мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, сургалт бэлтгэлийн тогтолцоог төлөвшүүлэх, анги, салбарын байлдааны бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадварыг дээшлүүлэхэд дорвитой арга хэмжээ авсан юм.

1979-1990 оныг хүртэлх хугацаанд химийн цэрэг нь армийн түүхэнд бүтэц зохион байгуулалтын хувьд олон төрлийн үүрэг гүйцэтгэх анги, салбаруудаас бүрдэж, шинэ техник хэрэгслээр хангагдан, цэргийн хими, хамгаалалтын мэргэжлийн академи, дээд, дунд сургууль төгссөн болон дотооддоо бэлтгэгдсэн боловсон хүчнээр бэхжиж, жинхэнэ тусгай мэргэжлийн цэрэг болж хөгжлийнхөө оргил үед хүрвэ.

1960-1979 онуудад нэгтгэл, ангиудыг өргөтгөн зохион байгуулах явцад тэдгээрийн орон тоонд байх химийн анги,

салбарууд өргөтгөн зохион байгуулагдаж байлаа. Тухайлбал, 1964 онд нэгдүгээр мотобуудлагын бригадэд химийн салааг, 1967 онд төмөр замын батальонд химийн тусгай ротыг, 1969 онд хоёрдугаар мотобуудлагын бригадэд химийн салааг, 1972, 1973 онд Баруун урт, Даланзадгад дахь мотобуудлагын тусгай батальонуудад химийн салааг тус тус байгуулж, 1973 онд хоёрдугаар мотобуудлагын бригадын химийн тусгай салааг рот болгон өргөтгөн зохион байгуулав.

Дээрх арга хэмжээний үр дүнд 1978 он гэхэд химийн цэргийн хэмжээнд хими хамгаалалтын тусгай батальон нэг, хими хамгаалалтын рот хоёр, хими хамгаалалтын салаа дөрөв, хими радиацийн тусгай тасаг хоёр, химийн төв агуулах, химийн засвар, лаборатори зэрэг анги, салбаруудтай болсон юм. Мөн энэ хугацаанд ардын цэргийн удирдах төв байгууллагад 1960-аад оны дунд үе хүртэл химийн цэргийн удирдлага нь АЦЕШ-ын химийн алба байсан бөгөөд 1971 онд ААЖШ-ын химийн хэлтсийг шинээр байгуулж, орон тооны албан тушаалтнуудаар нөхөн



АГВ-ын тасаг.....

хангасан. Тухайн үеийн химийн хэлтсийн даргаар С.Гомбодорж, Ж.Дашзэвэг, туслахаар Ш.Банзрагч, Б.Намхайнямбуу нар ажиллаж байлаа.

Армийн хими хамгаалалтын тусгай батальон буюу Зэвсэгт хүчний 119 дүгээр анги нь 1976 оны сургуулийн жилд онц ангийн болзлыг бүх үзүүлэлтээр хангаж

анх удаа онц ангийн алдрыг хүртэв. Түүнчлэн 1977 оны сургуулийн жилийн төгсгөлийн сайдын нэрэмжит шалгалтаар онц ангийн болзлыг бүрэн хангаж амжилтаа бататгаснаар анги байгуулагдсан 10 жилийн ойгоор БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн зарлигаар "Алтан гадас" одонгоор шагнагдсан түүхтэй.

ОЛОН УЛСЫН АРГА ХЭМЖЭЭНД ЦАЦРАГ, ХИМИ, БИОЛОГИС ХАМГААЛАХЫН ЦЭРГИЙН ОРОЛЦСОН БАЙДАЛ



Химийн зэвсэг хориглох конвенцбг хэрэгжүүлэх Үндэсний ажлын хэсгийг яам дундын хэлбэрээр 2001 онд байгуулав. Химийн зэвсэг хориглох олон улсын байгууллагад Химийн зэвсгийн шинжээчээр бригадын генерал М.Хүрлээ /1997-2002/, хурандаа

З.Нармандах /2003 оноос/, хурандаа Д.Эрдэнэцогт /2006 оноос/ тус тус томилогдон ажилласан.

Энэ хугацаанд НҮБ-аас Сирийн химийн дайныг зогсоохоор ХЗХБ (ОРСВ)-ийн 23 химийн зэвсгийн шинжээчийг илгээсний нэг нь хурандаа Д.Эрдэнэцогт байсан ба Сирид химийн зэвсэг ашиглахыг зогсоосон гавьяаг нь үнэлж эдгээр шинжээчдэд Нобелийн шагнал олгосон юм. Мөн дэлхий нийтийн энх тайвны төлөө хүчин зүтгэж, дайн тулааны халуун цэгүүдэд үүрэг гүйцэтгэх үйлсэд Зэвсэгт хүчний цацраг, хими, биологис хамгаалахын цэрэг амжилттай үүрэг гүйцэтгэсэн. Тухайлбал, Ирак, Афганистан, Сьерра Лион, Чад, БНЭСУ, Баруун Сахар зэрэг дэлхийн халуун цэгүүдэд цацраг, хими, биологис хамгаалахын цэргийн мэргэжлийн бие бүрэлдэхүүнүүд үүрэг амжилттай гүйцэтгэсэн бахдам түүхтэй.

